



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/84

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.10, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.1, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Эрдэнэбулган сумын төвийн урдуур урсдаг Эгийн гол 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн эргээ даван хальж, айл өрх, нойл, худаг болон хогийн цэгийн 2.1 га талбайд халиа орж усанд автсан бөгөөд цаашид мөс гэсэх явцад хог хаягдал, айл өрхийн нойлоор бохирдсон ус урсан Эгийн гол бохирдох эрсдэлтэй тул хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах зорилгоор шинээр хогийн цэг байгуулах, хуучин хогийн цэгийг зөөвөрлөн техникийн нөхөн сэргээлт хийх, хяналтын цооног гаргах, түр далан байгуулах ажилд мэргэжлийн байгууллагаас гаргасан судалгаа, тооцоог үндэслэн 50.000.000 (Тавин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 50.000.000 (Тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Эрдэнэбулган суманд шинээр хогийн цэг байгуулах, хуучин хогийн цэгийг зөөвөрлөн техникийн нөхөн сэргээлт хийх, хяналтын цооног гаргах, түр далан байгуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Эрдэнэбулган сумын Засаг даргын орлогч (Г.Баярбат) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Батлагдсан төсвийг ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжид шилжүүлэхдээ ажлын гүйцэтгэлийг харгалзан хэсэгчлэн олгох, зардалд хэмнэлт гарсан бол төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан үлдэгдлийг буцаан шилжүүлэхийг Эрдэнэбулган сумын Засаг дарга (Б.Эрдэнэнаран)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН